

Философи, шашин судлал-ХІV
ЭСТЕТИКИЙН ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДАЛД

Т.Дорждагва (Ph.D), профессор

Ч.Ичинхорлоо (Докторант)

МУИС. НШУС.

Философийн тэнхим

Түлхүүр үгс: Нэр томъёо, эстетик, aesthetikos “гоо зүй” гэдэг нэрлэлт, эстетикийн уламжлалт болоод уламжлалт бус категориуд, эстетикийн судлах үндсэн асуудлын хүрээ, эстетикийн зорилго

Онолын мэдлэг, тэр дундаа орчин үеийн шинжлэх ухаан, технологийн гол нэр томъёонуудыг үндэснийхээ бичиг үсгээр шууд буулган хэрэглэх практик нь олон улс орон, ард түмэнд нийтлэг байдаг жишиг юм. Ялангуяа энэ нь англи, франц, испани, герман, орос зэрэг дэлхийн түгээмэл хэрэглэгддэг хэлнүүдэд илэрхий харагддаг.

Дэлхийн II дайны үеийн хүнд жилүүдэд Зөвлөлтийн ард түмэн, төр, засгийн өгөөмөр дэмжлэг тусламжтайгаар манай эрдмийн эх уурхай болсон МУИС байгуулагдаж, монголчууд бид шинэ үеийн эрдмийн их сангаас хүртэх нэгэн сайхан боломж нээгдсэн билээ. Тэр үеэс орос хэлэн дээр хэвшиж тогтсон олон нэр томъёог манайд монгол хэл бичиг, авиан зүйн онцлогтоо нийцүүлэн шууд авч нутагшуулсан нь эдүгээ ч хэрэглэгдсээр байна. Тухайлбал, биологи, физик, хими, математик, геологи, палеонтологи, философи, логик, технологи гэх мэтчилэн тэдгээрийг энд тоочоод баршгүй.

Нөгөө талаар нэр томъёог эх хэлнээ хөрвүүлэн оноож хэрэглэх хэрэгцээ, шаардлага байлгүй яахав. Энэ бол соён гэгээрүүлэгч их ач холбогдолтой юм. Гол нь тэр хөрвүүлэгч түмэн олонд ойлгомжтой бөгөөд хүртээмжтэй байх нь чухал. Эс тэгвэл үр өгөөж муутай байдаг. Арав гаруй жилийн тэртээ бид соёлын онолд холбогдох орчин үеийн мэдлэгийн нэгэн төрлийг өөрийн орны боловсролын тогтолцоонд оруулж ирэх оролдлого хийхдээ “Соёл судлал” гэж нэрлэсэн нь эдүгээ оюутан залуусын сонгон судлах дуртай хичээлийн нэг болон хөрөвжсөн төдийгүй, хүн бүхний мэддэг нэр томъёо болжээ. Энд хүн төрөлхтөний түүхийн өнөө үеийн онцлог хийгээд шаардлага, манай орны гадаад болоод дотоод нөхцөл байдлын өөрчлөлт нөлөөлсөн нь ойлгомжтой.

Гэтэл аль нэгэн нэр томъёоны онолт өөрийнхөө агуулгыг бүрэн оновчтой, адъекват (өвч адил -Т.Д.) илэрхийлж чадаагүйгээс болж хэрэглээнээс гээгдэх, эсвэл хөгжлийнхөө явцад шинэчлэгдэх шаардлагатай байж болно. Тиймээс түүнийг хүчлэн орчуулах гээд байх нь зохимжгүй бөгөөд тэр нь урт насгүй болох мэт санагдана.

Бид энэ бүгдийн эцэст “туйлшрах хэрэггүй, ухаалаг шийдье, урт настай юм хийцгээе” л гэсэн санааг хэлэх гэсэн бөлгөө. Тэгээд:

*“Гоо зүй” гэдэг нь агуулгаа илэрхийлэхгүй болохоор
Гайгүй нэр хайрлах гэтэл чадахгүй юм чааваас гэж
Баумгартены нэрлэсэнээр, тэгээд бас нийтэд түгсэнээр нь
Бас л “эстетик” гэхээр шийдээд байгаа шүү өршөөгөөрэй³⁴*

гэсэн нэгэн эхлэн бичигчийн цөөхөн мөр санаанд бууж байгаад олзуурхаж байгаа юм. Харин одоо бид энэ тухай уншигч авхай таньтай саналаа солилцох хүсэлтэй байна. Гэхдээ бид энэ удаад эстетикт тодорхойлолт өгч, түүний бүтэц, функци, динамикийн тухай асуудлыг хөндөхийг урьдал болгохгүй, өөрөөр хэлбэл эстетик онолд холбогдох асуудлыг түр хойш тавьж, голчлон сургалт, судалгааны практикт холбогдох цөөхөн асуудалд сэтгэл зовинож байгаагаа илэрхийлэх гэсэн юм.

Энд дурдагдан байгаа томъёололыг германы философич А.Баумгартен ХҮШ зуунд анх эрдэм судалгааны эргэлтэнд оруулсан байна. Тэрээр грек хэлний *aisthetikos* буюу мэдэрч хүртэхүйд хамаарагдах гэсэн утгатай үгнээс үүдэн өөрийн “*Aesthetica*” (1750-1758)³⁵ номондоо уг нэр томъёог анх хэрэглэжээ. Эстетик мэдрэмж, эстетик ухамсар, эстетик үйл ажиллагаа зэрэг нь анхнаасаа л соёлд, өөрөөр хэлбэл хүмүүнд холбогдож ирсэн хэдий ч эстетикийг философийн салбар, онол болох хувьд нь харьцангуй хожуу боловсруулсан байдаг. Харин эстетикийн үр хөврөлийг эртний шидэт домгоос олж үзэж болох ба түүний үүсэл, хөгжил өнө эртний уламжлалтай холбоотой юм.

Уламжлалт эстетикийн гол ойлголтууд болох гоё, сайхан, бадрангуй, эмгэнэл, шог, ариусал, зохирол, журам, урлаг, хэмнэл, яруу сайхны зарчим, уран илтгэхүй, хөгжим, калокагати³⁶, канон³⁷, элэглэл, мимесис³⁸ бэлгэ тэмдэг, дүр, тэмдэг, гэрэл, өнгө болон бусад

³⁴ Энэхүү өгүүллийг бичигч нэгэн мэргэжил нэгт анддаа дурсгасан өөрийн бүтээл дээрээ эл мөрүүдийг тэмдэглэж үлдэсэнээс ишлэн авав.

³⁵ Никитина И.П. *Философия искусства: учеб. пособие. 3-е изд., испр.* - М.: Издательство “Омега-Л”, 2010. номын 35 дахь талд

³⁶ Хүний гадаад болон дотоод талын зохиролыг тэмдэглэдэг Эртний Грек, Ромын соёлд өргөн дэлгэрсэн нэр томъёо, хүний сайн сайхны гол нөхцөл юм. Тухайн үедээ энэ нь ариун шударга ёс, баялаг, гоо сайхан, хүний бие бялдар хийгээд оюуны чадварын хослол, хүмүүжлийн чин эрмэлзлэл болж байжээ.

³⁷ Хоруженко К.М. *Культурология. Энциклопедический словарь.* – Ростов на Дону: Изд-во “Феникс”, 1997. толийн 190-191 дэх талд үзнэ үү (Энэ нь хэм хэмжээлэг үлгэрлэл, аль нэгэн цаг үеийн дүрслэх урлагт заавал баримталдаг уран сайхны арга барил, дүрмүүдийн цогцийг тэмдэглэх дүрэм, хэм хэмжээ, хэмжүүр гэсэн утгатай *канон* гэдэг грек гаралтай үг).

³⁸ Хоруженко К.М. *Культурология. Энциклопедический словарь.* – Ростов на Дону: Изд-во “Феникс”, 1997. толийн 307 дахь талд үзнэ үү (Энэ нь Аристотелийн хэлсэн гадаад ертөнц хийгээд уран бүтээлийн хоорондох харилцааг тодорхойлдог эстетик нэр томъёо юм. Уран баримал, яруу найраг, зарим тохиолдолд хөгжимд байгалийг хуулбарлахгүйгээр дуурайх, түүнийг шинэ хэлбэрүүдээр баяжуулах нь бий.)

ойлголтууд эртний Грект³⁹ буй болжээ. Түүнээс хойш уламжлалт эстетик үүсэж, хөгжсөн урт удаан цаг хугацааг туулан өнгөрүүлэхдээ нийгмийн социаль талуудаас хүний мэдрэмжид илүү холбогдох онцгой нэгэн тал болох эстетик талын тухай арвин баялаг мэдлэгийг хуримтлуулан тээж, өвөрмөц арга зүйг боловсруулж ирснээрээ хүн төрөлхтөний түүхэнд хосгүй гавъяатай, нандин эрдэм болж түүхэнд үлдсэн юм. Манай оронд гэхэд л энд Ч.Лодойдамба, С.Баясгалан, Хо.Нацагдорж, С.Лувсанвандан, Р.Рэгзэндорж, Ү.Нямдорж, Ж.Төмөрбаатар зэрэг ахмадууд болон олон эрдэмтэн судлаачид чухал хувь нэмэр оруулж ирснийг дурдахад таатай байна. Харин хожим нь, нэн ялангуяа ХІХ зуунд эхлэлээ тавьсан орчин үеийн эстетикт эдгээр ойлголтуудын утга санаа цагийн эрхээр ихэд өөрчлөгдсөн болохыг тэмдэглэх нь зүйтэй юм.

Эстетик нь үндсэндээ удаан хугацааны турш “сайхан”-ы философи байж хөгжжээ. Энэ нь ялангуяа сүүл үедээ албан ёсны нэг үзэл сурталд хэт автагдаж байсны үр дагавар ч байж болно. Гэтэл өнөөдөр сайхны тухай философи болох эстетикийн зарим үндэслэл, тодорхойлолт зохих утгаар хуучирсан гэж хэлж болохоор байна. Учир юун гэвэл “Сайхан” бол “бадрангуй”, “гутамшигт”, “муухай”, “хошин”, “эмгэнэл”, “егөөдөл”, “бурлеск”⁴⁰, “гротеск”⁴¹ гэх мэт эстетик зүйлүүдийн адил зөвхөн нэг л төрөл хувилбар нь юм. Энэ тухай Л.Витгенштейн: “Минийхээр эстетикийн судлагдахуун бол маш уужим өргөн зүйл. Бүр буруу ойлгогдоод байх юм”⁴² гэж бичжээ. Энд Витгенштейн “Сайхан”-ы тухай категорын ач холбогдлыг уламжлалт эстетик илэрхий хэтрүүлэн үнэлж байсанд анхаарлаа хандуулсан байдаг. Өөрөөр хэлбэл “Сайхан” нь эстетикийн бусад категориудаас тэргүүлэх чанартай байх албагүй гэсэн санаа. Энэ тухай жишээ нь, орос хэл дээр хэвлэгдсэн зарим бүтээлд: Бодит амьдрал дээр эстетик бодомжийг бид сайтар бодож боловсруулахад “красивый”, “изящный” гэх мэт тэмдэг нэр бараг ямарч үүрэг гүйцэтгэдэггүй юм⁴³ гэж дурджээ.

Тэр тусмаа энэ салбарын мэдлэгийг манайд орос хэлнээс орчуулж хэрэглэсэн байдлыг харахад нэн “эмгэнэлтэй” зүйл ажиглагдана. Жишээ нь мэдлэгийн салбар болох “Эстетика”-ийг “Гоо зүй” гэж буулгасан нь яая гэхэв гэж бодоход түүний судлагдахуун болох “эстетическое” гэдгийг “гоо сайхан” гэж эндүүрэн буулгасан нь элбэг үзэгдэнэ. Энэ утгаар

³⁹ Никитина И.П. *Философия искусства: учеб. пособие. 3-е изд., испр.* - М.: Издательство “Омега-Л”, 2010. номын 40 дахь талд үзнэ үү.

⁴⁰ *Словарь иностранных слов. – 18-е изд., стер.* – М.: Рус. яз., 1989. толийн 94 дэх талд үзнэ үү (Урлагийн шоглон элэглэх хошин төрөлийг тэмдэглэх burlesque гэсэн франц гаралтай үг).

⁴¹ А) Хоруженко К.М. *Культурология. Энциклопедический словарь.* – Ростов на Дону: Изд-во “Феникс”, 1997. толийн 111 дэх тал, Б) *Словарь иностранных слов. – 18-е изд., стер.* – М.: Рус. яз., 1989. толийн 147-148 дахь талд үзнэ үү (Дүрслэх болон театрын урлаг, уран зохиол, хэвлэлийн урлаг дахь зөгнөлт хэтрүүлэг, зэмдэглэн дүрсэлсэн хошигнолын төрлийг тэмдэглэх grotesque гэсэн франц гаралтай үг).

⁴² Витгенштейн Л. *Лекции и разговоры об эстетике, психологии и религиозной вере // Современная западноевропейская и американская эстетика.* М., 2002. номын 37 дахь талд

⁴³ Никитина И.П. *Философия искусства: учеб. пособие. 3-е изд., испр.* - М.: Издательство “Омега-Л”, 2010. номын 36 дахь талд үзнэ үү.

бол утгаа эстетик зүйл болох “гугамшиг”, “муухай”, “эмгэнэл” бол “гоо сайхан” зүйл байх нь. Үүнийг яаж цааш нь ойлгох вэ? Ийм л юм болж. Нэгэн цогц онигоо хүртэл гарсныг сайн санаж байна. Түүний тэргүүн хэсэг гэвэл: нэгэн ажилтан хөөрхий минь даргынхаа даалгаварыг биелүүлэхээр “союз”-д төгссөн найздаа ханджээ. Гэтэл найз нь “эстетическое” гэдэг нэр томъёог “гоо зүйл” гээд орчуулаад өгсөн нь дээр дурдсантай агаар нэгэн боловч бас ч гэж хэл гадарладаг байсных ... Удаахи ноцтой “инээдэмтэй” хэсэг нь гэвэл: “Гоо зүй” гэдгийг “гоо зүйл” гээд халыг сонссоноороо биччихэж гээд дарга нь түс хийтэл инээсэнд оршино.

Ийм учраас энэ чиглэлийн мэдлэгт холбогдох нэр томъёоны асуудалд анхаармаар зүйлүүд гараад байгаа юм. Тухайлбал, манай орос монгол тольд “возвышенный”⁴⁴ гэдэг тэмдэг нэрийг “эрхэм дээд, ариун сайхан” гэж хөрвүүлжээ. Гэтэл орос хэлэнд түүнийг “возвышенное” хэмээн категори болгон хэрэглэсэнийг манайд “бадрангуй”, эсвэл “гайхамшигт” гэх мэтээр буулган ярьж, бичиж байх нь үзэгддэг. Энэ мэт жишээг олноор нь дурдаж болох ба ялангуяа наанадаж сургалтын хэрэгцээг бодолцон нэр томъёоны асуудлыг цэгцлэх шаардлага гарч байна.

Орчин үеийн судлаачдын бүтээлээс тоймлон үзвэл эстетик зүйлийн хүрээ, түүнтэй холбогдон эстетикийн судлах зүйл шинэ үед ер бусаар өргөснө. Эстетик категорын жагсаалтад дуусгавар байхгүй, эстетик зүйлийн хүрээ өөрчлөгдөхтэй хамт тэдгээрийг шинжилдэг ерөнхий ойлголтууд өөрчлөгдөн солигдоно гэж итгэлтэй дуугарах нь тодхон анзаарагдах боллоо. Бас “эстетик” гэдэг нэр томъёо одоо өөр утгаар, эстетик соёлыг бүрдүүлэх зүйлс, түүний эстетик компонентуудыг тэмдэглэхэд хэрэглэгдэх болов гэдэг. Тиймээс энэ утгаар зан үйл, аль нэгэн үйл ажиллагаа, спорт, сүмийн ёслол, цэргийн ёслолын дэг болон ямар нэг объект гэх мэтийн эстетикийн тухай ярьж, бичиж байна.

Тэгэхлээр эстетикийн судлах үндсэн асуудлын хүрээнд эстетик мэдрэхүй хийгээд үзэл, уран сайхны таашаал хийгээд чин эрмэлзлэл, тэрчлэн эстетик ухамсрыг бүрдүүлэх бусад зүйлсийг хамруулан үзэж, түүний категорийн аппаратыг нарийвчлан боловсруулах нь эстетикийн өнөөгийн тулгамдсан чухал зорилт болж байна. Эстетикийн үндсэн категорит эстетик зүйл, сайхан, бадрангуй, муухай, гугамшигт, эмгэнэл, хошин, егөөдөл, мимизис, катарсис (ариусал-Т.Д.⁴⁵), уран сайхны дүр, бэлгэ тэмдэг, канон, уран сайхны хэв загвар, урлаг, тоглоом гэх зэргээр олныг тоочин оруулж болох юм.

⁴⁴ Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв. *Орос монгол толь. II хэвлэл.* – УБ.: Улсын хэвлэлийн газар, 1982. толийн 55 дахь талд

⁴⁵ Т.Дорждагва. *Философийн зарим нэр томъёо. Тэргүүн дэвтэр (Монгол-англи-орос-герман хэл дээр).* – УБ.: БИТПРЕСС, 2012. – 108 тал товхимолыг үзнэ үү.

Эцэст нь бид философийн салбар болох эл мэдлэгийг “Эстетик”⁴⁶ хэмээн нэрлэж, чухамхүү энэ хүрээнд хамаарах мэдрэмж, үнэлэмж, хэм хэмжээ, чин эрмэлзлэл, зарчим, хандлага, таашаал, үзэл, сэтгэлгээ, ухамсар, соёл, үйл ажиллагаа, ойлголт, категори, онол, дүгнэлт ... гэхчлэн аливаа ... г “эстетик” гэсэн тэмдэг нэрийн хамт хэрэглэж заншихыг төр, түмэндээ санал болгож байна. Энд А.Баумгартен эл мэдлэгийн хүрээг анхлан нэрлэхдээ яагаад өөрийн төрөлх хэл дээрх ойлголт, нэр томъёог ашиглалгүйгээр грек үг хэрэглэсний учрыг эргэн нэг санахад илүүдэхгүй буй заа.

Дашрамд дурдахад хууль болон албан ёсны соёлын бүхий л түвшинд хүртэл асуудал ийм байгааг анхааран соёрхоно уу.

НОМ ЗҮЙ

1. Витгенштейн Л. Лекции и разговоры об эстетике, психологии и религиозной вере // Современная западноевропейская и американская эстетика. М., 2002.
2. Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв. Орос монгол толь. II хэвлэл. – УБ.: Улсын хэвлэлийн газар, 1982.
3. Т.Дорждагва. Соёл судлал. Сурах бичиг. III хэвлэл. – УБ.: БИТПРЕСС, 2011.
4. Т.Дорждагва. Философийн зарим нэр томъёо. Тэргүүн дэвтэр (Монгол-англи-орос-герман хэл дээр). – УБ.: БИТПРЕСС, 2012.
5. Никитина И.П. Философия искусства: учеб. пособие. 3-е изд., испр. - М.: Издательство ”Омега-Л”, 2010.
6. Словарь иностранных слов. – 18-е изд., стер. – М.: Рус. яз., 1989.
7. Хоруженко К.М. Культурология. Энциклопедический словарь. – Ростов на Дону: Изд-во “Феникс”, 1997.

SUMMARY

At first, authors of this article concerned problems of term and criticized that translation of term “Aesthetikos” into Mongolian language like “Гоо зүй” is not accord with content of its discipline. Instead, they recommend to name it as “Эстетик”. Also, authors sharply criticized that contents of main understandings and categories of this discipline was confused tremendously.

⁴⁶ Т.Дорждагва. Философийн зарим нэр томъёо. Тэргүүн дэвтэр (Монгол-англи-орос-герман хэл дээр). – УБ.: БИТПРЕСС, 2012. Товхимолын 16 дахь талд үзнэ үү (Энэ нь эдүгээ албан ёсоор хэрэглэгдэж байгаа крилл бичиг үсгээр тэмдэглэнэ гэсэн санаа юм.)